



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.5, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баянхонгор аймаг дахь Политехник коллеж үндсэн хөрөнгөд бүртгэлтэй сэргээн засварлах боломжгүй болсон нийт 5,644,516.00 (таван сая зургаан зуун дөчин дөрвөн мянга таван зуун арван зургаан) төгрөгийн балансын үнэ, 3,386,709.62 (гурван сая гурван зуун наян зургаан мянга долоон зуун есөн төгрөг жаран хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 1 ширхэг агуулахын барилгыг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн захирал Д.Бат-Орших нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Хөрөнгийг акталж буулгах, газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБАЯР

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн
347 дугаар тогтоолын хавсралт



Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн
үндсэн хөрөнгөд бүртгэлтэй актлах агуулах

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Агуулах /Хуучин складны барилга/	1994	Баянхонгор аймаг Номгон 1-р баг	5,644,516.00	3,386,709.62	2,257,806.38
	Нийт дүн			5,644,516.00 (таван сая зургаан зуун дөчин дөрвөн мянга таван зуун арван зургаан)	3,386,709.62 (гурван сая гурван зуун наян зургаан мянга долоон зуун есөн төгрөг жаран хоёр мөнгө)	2,257,806.38 (хоёр сая хоёр зуун тавин долоон мянга найман зуун зургаан төгрөг гучин найман мөнгө)